

# Хүн бүхний нийгмийн даатгал!!

## Нийгмийн даатгал юунаас эхэлдэг вэ?

- ◆ Таны бүхэл амьдралын турш тохиолдож болох эрсдэлүүд.

Өвчин тусах



Гэмтэл авах



Өтлөх



Тахир дутуу болох

- ◆ Хувь хүнд тохиох эрсдэлийг урьдчилан мэдэх бол маш хэцүү. Өөрийгөө хэзээ өвдөх эсвэл хэзээ ямар гэмтэл авах, хэр удаан хугацаанд амьдрах эсвэл ямар шалтгаанаар тахир дутуу болохоо хэн ч мэдэхгүй.
- ◆ Үүнээс гадна, нийгмийн ба эдийн засгийн нөхцөл байдлыг таамаглах боломжгүй байдаг. Хувь хүн энэ бүхэнд бүрэн бэлтгэлтэй байх боломжгүй ба **нийгмийн даатгал** нь бие биенээ бүх нийтээрээ туслах болон дэмжих схем юм.

## Эрүүл мэндийн даатгал ба тэтгэврийн даатгал

- ◆ Нийгмийн даатгалын тогтолцооны дагуу даатгалын шимтгэлийг төлснөөр, танд учирсан гэнэтийн бэрхшээлд та ашиг тусыг хүлээн авах боломжтой.

### ◆ Жишээлбэл:

- Та өвчин тусах эсвэл гэмтэл авсан тохиолдолд **эрүүл мэндийн даатгал** нь аливаа нэгэн эмнэлгийн байгууллага дахь эмчилгээ үйлчилгээний төлбөрийг багаар төлөх боломжийг танд олгоно.
- Та өтлөх эсвэл аливаа нэгэн шалтгаанаар тахир дутуу болсон бол тогтмол байдлаар тэтгэвэр авах боломжийг **тэтгэврийн даатгал** бүрдүүлэх болно.

Нийгмийн даатгал нь бүх нийтийн тогтолцоо, нийтээр мөрдөх дүрэм бөгөөд, Япон улсад амьдарч буй хэн бүхэн, япон иргэн болон япон иргэн бус үндэстэн үл харгалзан, нийгмийн даатгалд хамрагдах ёстой.